



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2019 оны 05 сарын 02 өдөр

Дугаар А/262

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны 8 дугаар хуралдааны 8/04 дугаар тогтоолын 5 дугаар хавсралтын 5.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Ховд аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 9 дүгээр сарын 28-ны өдрийн 98 дугаар тогтоолоор батлагдсан Төлөөлөгч хөтөлбөрийн санхүүжилтээс Өмнөговь аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын үйл ажиллагаатай танилцаж, туршлага судлах, аймгийн бүтээн байгуулалт, Оюу толгойн далд уурхайтай танилцах, Улаанбаатар хотод гэр хорооллын дахин төлөвлөлт, нийслэлийн иргэдийн төлөөлөгчийн туршлага судлах арга хэмжээнд аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчид, ажлын албаны ажилтанууд, сумдын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, нарийн бичгийн дарга нарыг оролцуулах арга хэмжээний зардалд 21.630.000 төгрөг /Хорин нэгэн сая зургаан зуун гучин мянга/-ийг хавсралтаар баталж зарцуулсугай.

2. Дээрх арга хэмжээний санхүүжилтийг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны 8 дугаар хуралдааны 8/04 дугаар тогтоолын 5 дугаар хавсралт, Хөшөөт хөгжил сангийн хөрөнгө оруулалтын жагсаалтын 5.3 дахь заалтаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/-д зөвшөөрсүгэй.


3. Энэхүү захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Энхболд/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА  Б. ДҮГЭРЖАВ



02-01000

Аймгийн Засаг даргын 2019 оны  
05 дугаар сарын 03-ны өдрийн  
А/262 дугаар захирамжийн хавсралт



### ЗАРДЛЫН ТООЦОО

Д/д	Зардлын зүйл	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгж үнэ	Нийт зардал
1	Автобусны шатахуун /100 км-т 40 л/	литр	2000	2400	4,800,000
2	Хоолны зардалд	хүн	35	180000	6,300,000
3	Буудлын тооцоо	хүн	35	150000	5,250,000
4	Гарын бэлэг	хүн	30	20000	600,000
5	Бэлэг дурсгал	ши	5	200000	1,000,000
6	Автобусны хөлс		1	3180000	3,180,000
7	Бусад зардал		1	500000	500,000
	Нийт зардал				21,630,000